



НИЙСЛЭЛИЙН ХУДАЛДАН АВАХ АЖИЛЛАГААНЫ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2026 оны 02 сарын 04 өдөр

Дугаар А/36

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Засгийн газрын 2025 оны "Журам батлах тухай" 43 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын 4.4 дэх заалт, мөн тогтоолын гуравдугаар хавсралтаар баталсан "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2.1 дэх заалт, 2022 оны А/1205 дугаар захирамжаар баталсан "Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын дүрэм"-ийн 7.1.1 дэх заалт, Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын даргын 2025 оны А/32 дугаар тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам шинэчлэн батлах тухай" журмын 7.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хяналт-шинжилгээ, үнэлгээний чиглэлээр 2026 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө"-г хавсралтаар баталсугай.

2. Төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг хагас, бүтэн жилээр тайлагнахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэн (Ө.Оюунчимэг)-т даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хууль, эрх зүйн хэлтэс (Г.Анар)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Д.БАТЦЭЦЭГ

1725010118

1	2	3	4	5	6	7
	байгууллагаас ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтэд үнэлгээ хийнэ.			үнэлж, НЗДТГ-т тайлагнахад хяналт тавин ажилласан байна.		
Зорилт 2. Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, зөвлөмж гаргах, үр дүнг дээшлүүлэх ажлыг зохион байгуулах ажлын хүрээнд:						
4	Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт (тайлан)-д хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	-	Зөвлөмжийн тоо	Зөвлөмжийг Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулна.	06 сард	12 сард
5	Байгууллагын зохион байгуулалтын нэгжүүдийн гүйцэтгэлийн тайланд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	-	Зөвлөмжийн тоо	Холбогдох нэгжид зөвлөмж өгч, шаардлагатай тохиолдолд удирдлагад санал хүргүүлнэ.		Жилд нэг удаа
6	Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг, даалгаврын биелэлтэд үнэлгээ өгнө.	-	Өгсөн үүрэг, даалгаврын тоо, Үнэлгээний дундаж хувь	Нийслэлийн удирдах ажилтнуудын шуурхай зөвлөгөөн дээр өгсөн үүрэг, даалгаврын биелэлтийн хэрэгжилтэд үнэлгээ өгч, удирдлагад мэдээлэл өгсөн байна.		Тухай бүр
7	Газрын Удирдлагын зөвлөлийн хурлаас өгсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд үнэлгээ өгнө.	-	Өгсөн даалгаврын тоо, Үнэлгээний дундаж хувь	Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг биелэлтэд үнэлгээ өгч, удирдлагад хэрэгжилтийн талаар мэдээлэл өгсөн байна.		Тухай бүр
Зорилт 3. Бусад чиг үүргийн хүрээнд:						
8	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгнө.	-	2 удаа	Өргөдөл, гомдлын шийдвэрлэлттэй холбоотой зөвлөмж өгч, тайлангийн үр нөлөө, шийдвэрлэлт сайжирсан байна.	04 сард	10 сард

1	2	3	4	5	6	7
9	Албан бичиг шийдвэрлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөмж өгнө.	-	2 удаа	Албан бичиг шийдвэрлэлтийн тайланд зөвлөмж өгч, тайлангийн үр нөлөө, шийдвэрлэлт сайжирсан байна.	02 сард	11 сард
10	Удирдлагаас өгсөн чиглэлийн дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	-	Зөвлөмжийн тоо	Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагад бодит нөхцөл байдлын талаар танилцуулсан байна.	Тухай бүр	
11	Төрийн албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах тухайн жилийн хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ.	-	1 удаа	Хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, удирдлагад танилцуулж, шийдвэр гаргахад нь дэмжлэг үзүүлсэн байна.	12 сард	-